



“МИАТ” ТӨХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.09.09 № 01/1537

танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай компаниас зарласан “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал” МИАТ/20240103122 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Тэнгэр даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК-уудаас тус тус гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-д “Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: “Шаардана”,...б) Даатгалын салбарт үүний дотор давхар даатгалын салбарт 5 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой...хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж, 15 дугаар зүйлийн 15.1-д “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэж, 17 дугаар зүйлийн 17.2-т “Техникийн чадавх, туршлагын талаарх мэдээллийг дараах баримт бичгээр нотолж болно:” гэж, 17.2.3-т “гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын даатгалын зах зээлд давхар даатгалын чиглэлээр нэг аж ахуй эрхлэгч үйл ажиллагаа явуулж байх бөгөөд тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д заасан дээрх шалгуур үзүүлэлт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 15 дугаар зүйлийн 15.1-д заасныг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”, Сүүлийн 3 жилд “МИАТ” ТӨХК-тай даатгалын /агаарын хөлгийн болон бусад төрлийн даатгал/ үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байсан бол гэрээний биелэлтийг дүгнэсэн гэрээ дүгнэсэн акт, хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний хувьд явцын гэрээ дүгнэсэн акт ирүүлнэ.” гэж заасан байна.

“Практикал даатгал” ХХК-аас гаргасан гомдолд дурдсан 2022-2023 оны хугацаанд “МИАТ” ТӨХК-тай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэсэн актыг гаргаж

0003832

өгөхгүй байгаа гэх асуудал нь тус газарт хуулиар олгосон чиг үүрэгт хамаарахгүй тул гомдлоо холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн хариуг хүргүүлсэн болно.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1.2-т “Нөхөн төлбөр - Сүүлийн 3 жилийн нөхөн төлбөр олголтын дундаж зардал нь төсөвт өртгийн 40%-иас багагүй байх. /Санхүүгийн зохицуулах хорооны албан бичгээр ирүүлэх/” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Техникийн чадавх, туршлагын талаарх мэдээллийг дараах баримт бичгээр нотолж болно.” гэж, 17.2.2-т “бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/260 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Жишээ: батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [●] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг ТШЗ 17.2-т заасан хугацаанд доод тал нь [●] удаа байх. Захиалагч ижил төстэй үйлчилгээг тухайлан зааж болно.]” гэж тус тус заасан байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Даатгалын салбарын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан”-гаас үзэхэд ердийн даатгалын нийт 16 компаниас 8 компани нь тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.2-т заасан шалгуур үзүүлэлтийг хангахаар байх тул өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй бөгөөд захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.2-т заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу боловсруулсан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.



Б.БИЛГҮҮН